

**ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧИЙН
2020 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД
ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт

Агуулга

1.Төрийн аудитын санал, дүгнэлт	3
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	7
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	9
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	11
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	12
2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан	14
3. Аудитын тайлан.....	14
3.1. Ерөнхий зүйл.....	15
3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй.....	15
3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт	16
3.4. Материаллаг байдал	16
3.5. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд	16
3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт	18
3.7. Шилэн дансны мэдээлэл.....	19
3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	19
3.9. Аудитын илрүүлэлт.....	19
Залруулсан алдаа.....	19
Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил	20
Аудитын зөвлөмж.....	20
3.10. Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд	20
4. Менежментийн захидал	20
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт	23



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

МАЛЫН УДМЫН САНГИЙН
ҮНДЭСНИЙ ТӨВИЙН ЗАХИРАЛ
П.ГАНХУЯГ ТАНАА

2021.02.25 № 07/476

танай _____-ны № _____-т

Аудитын санал, дүгнэлт

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Малын удмын сангийн үндэсний төвийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Малын удмын сангийн үндэсний төвийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл материаллаг алдаагүй Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан холбогдох журамд нийцүүлэн үнэн зөв, шударга толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, гарын авлагын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторовын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэс болно.

Бусад мэдээлэл

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 10 зорилтын хүрээнд 21 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 90 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч нь санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан холбогдох журам, зааврын дагуу үнэн зөв, шударга бэлтгэж, толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэж болох материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтуудыг хэрэгжүүлэх хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар түүнийг бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН ЗАХИРАЛ,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2. Аудит хийсэн санхүүгийн тайлан

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан /төгрөгөөр/

Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>7,403,081,578.36</u>	<u>7,034,402,027.01</u>
МӨНГӨН ХӨРӨНГӨ	93.85	-
Кассад байгаа бэлэн мөнгө	93.85	-
Төгрөг	93.85	-
АВЛАГА	2,848,131,705.41	2,725,420,369.09
Ажиллагчидтай холбогдсон авлага	-	36,960.50
Бусад авлага	2,848,131,705.41	2,725,383,408.59
Байгууллагаас авах авлага	2,478,865,692.00	2,478,063,239.45
Хувь хүмүүсээс авах авлага	331,934,518.31	209,988,674.04
Ажилчдаас авах авлага	37,331,495.10	37,331,495.10
БАРАА МАТЕРИАЛ	4,554,949,779.10	4,308,981,657.92
Түүхий эд материал	105,350,633.42	164,873,054.76
Тусгай зориулалттай материал	105,350,633.42	164,812,334.76
Эм боох материал	-	60,720.00
Бэлэн бүтээгдэхүүн	1,314,539,252.99	1,264,943,705.39
Хангамжийн материал	94,826,026.48	119,361,433.56
Бичиг хэргийн материал	90,000.00	139,000.00
Аж ахуйн материал	57,589,625.07	37,932,810.00
Сэлбэг хэрэгсэл	979,000.00	2,578,000.00
Түлш, шатах тослох материал	2,604,146.91	53,956,852.06
Хүнсний материал	-	515,825.00
Бусад хангамжийн материал	33,563,254.50	24,238,946.50
Мал амьтад	3,040,233,866.21	2,759,803,464.21
ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>17,600,027,452.01</u>	<u>17,251,345,808.86</u>
ҮНДСЭН ХӨРӨНГӨ	17,600,027,452.01	17,251,345,808.86
Биет хөрөнгө	16,709,199,589.51	16,360,006,696.36
Барилга, байгууламж, орон сууц	14,531,830,823.49	14,531,830,823.49
Хуримтлагдсан элэгдэл	(787,299,884.67)	(1,281,003,374.60)
Авто-тээврийн хэрэгсэл	238,484,853.60	339,775,168.60
Хуримтлагдсан элэгдэл	(193,904,694.58)	(223,222,884.35)
Машин тоног төхөөрөмж (компьютер)	3,565,380,199.06	3,746,090,086.06
Хуримтлагдсан элэгдэл	(1,200,610,871.12)	(1,223,984,740.42)
Тавилга, аж ахуйн эд хогшил	578,896,351.49	578,896,351.49
Хуримтлагдсан элэгдэл	(149,771,774.53)	(220,603,110.85)
Бусад үндсэн хөрөнгө	178,242,924.00	178,242,924.00
Хуримтлагдсан элэгдэл	(82,289,981.63)	(96,256,191.46)
Дуусаагүй барилга, байгууламж	30,241,644.40	30,241,644.40
Биет бус хөрөнгө	890,827,862.50	891,339,112.50
Программ хангамж	4,526,000.00	5,626,000.00
Хуримтлагдсан элэгдэл	(2,616,937.50)	(3,205,687.50)

Малын удмын сангийн үндэсний төвийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Бусад биет бус хөрөнгө	888,918,800.00	888,918,800.00
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>25,003,109,030.37</u>	<u>24,285,747,835.87</u>
НИЙТ ӨР ТӨЛБӨР	13,101,675.89	97,745,857.36
БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	13,101,675.89	97,745,857.36
Өглөг	13,101,675.89	97,745,857.36
Ажилчидтай холбогдсон өглөг	11,392,984.88	7,455,542.36
Бусад өглөг	1,708,691.01	90,290,315.00
Байгууллагад төлөх өглөг	1,708,691.01	90,290,315.00
ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>24,990,007,354.48</u>	<u>24,188,001,978.51</u>
Засгийн газрын хувь оролцоо	24,990,007,354.48	24,188,001,978.51
Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	1,604,070,935.15	1,604,070,935.15
Өмч: - төрийн	1,604,070,935.15	1,604,070,935.15
Хуримтлагдсан үр дүн	22,777,002,054.93	21,974,996,678.96
Өмнөх үеийн үр дүн	20,069,466,006.47	22,782,561,060.69
Тайлант үеийн үр дүн	2,707,536,048.46	(807,564,381.73)
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	608,934,364.40	608,934,364.40
ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>25,003,109,030.37</u>	<u>24,285,747,835.87</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан /төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	<u>4,410,197,239.92</u>	<u>1,105,089,243.00</u>
ТАТВАРЫН БУС ОРЛОГО	3,806,375,639.92	255,867,943.00
Нийтлэг татварын бус орлого	3,806,375,639.92	255,867,943.00
Төсөв байгууллагын өөрийн орлого	3,806,375,639.92	255,867,943.00
Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	206,834,412.79	5,512,000.00
Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	11,978,000.00
Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	3,599,541,227.13	238,377,943.00
ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	603,821,600.00	849,221,300.00
Улсын төвлөрсөн төсвөөс	587,143,100.00	817,708,200.00
Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	587,143,100.00	817,708,200.00
Нэмэлт санхүүжилтийн орлого	16,678,500.00	31,513,100.00
Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	16,678,500.00	11,213,100.00
Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	20,300,000.00
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	<u>2,073,146,704.71</u>	<u>1,924,971,677.35</u>
УРСГАЛ ЗАРДАЛ	2,073,146,704.71	1,924,971,677.35
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,035,310,090.78	1,856,232,942.69
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	269,359,466.22	427,264,981.32
Үндсэн цалин	221,811,211.44	379,751,262.32
Нэмэгдэл	27,443,254.78	39,143,719.00
Унаа хоолны хөнгөлөлт	20,105,000.00	8,370,000.00
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	38,223,032.28	52,353,535.86
Тэтгэврийн даатгал	26,543,086.75	36,456,853.03
Тэтгэмжийн даатгал	2,871,908.02	4,281,198.36
ҮОМШӨ-ний даатгал	2,667,118.16	3,340,963.09
Ажилгүйдлийн даатгал	552,758.53	746,122.25
Эрүүл мэндийн даатгал	5,588,160.82	7,528,399.13
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	100,831,177.02	44,468,068.80
Гэрэл, цахилгаан	26,743,489.00	30,039,050.80
Түлш, халаалт	65,794,981.02	-
Цэвэр, бохир ус	5,892,707.00	3,869,018.00
Байрны түрээс	2,400,000.00	10,560,000.00
Хангамж, бараа материалын зардал	23,820,376.48	115,832,604.83
Бичиг хэрэг	2,879,100.00	3,144,000.00
Тээвэр, шатахуун	15,337,177.00	86,608,605.14
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	4,057,839.48	5,672,749.62
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,546,260.00	20,407,250.07
Нормативд зардал	3,998,500.00	10,123,530.00

Малын удмын сангийн үндэсний төвийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	-	6,998,180.00
Хоол, хүнс	-	3,125,350.00
Нормын хувцас, зөөлөн эдлэл	3,998,500.00	-
Эд хогшил, урсгал засварын зардал	10,225,270.00	6,510,730.00
Багаж, техник, хэрэгсэл	1,205,980.00	-
Урсгал засвар	9,019,290.00	6,510,730.00
Томилолт, зочны зардал	4,765,156.15	3,895,000.00
Дотоод албан томилолт	4,765,156.15	3,895,000.00
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	398,438,268.62	247,247,038.42
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	397,755,544.62	246,831,908.42
Даатгалын үйлчилгээ	-	115,830.00
Тээврийн хэрэгслийн татвар	613,564.00	277,300.00
Тээврийн хэрэгслийн оношилгоо	-	22,000.00
Газрын төлбөр	69,160.00	-
Бараа үйлчилгээний бусад зардал	1,185,648,844.01	948,537,453.46
Бараа үйлчилгээний бусад зардал	420,753,016.98	316,755,608.31
Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	764,895,827.03	631,781,845.15
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	37,836,613.93	68,738,734.66
Бусад урсгал шилжүүлэг	2,771,580.00	56,000,083.80
Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	2,771,580.00	-
Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	-	54,300,083.80
Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	-	1,700,000.00
Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	35,065,033.93	12,738,650.86
Төвлөрүүлэх шилжүүлэг	35,065,033.93	12,738,647.86
Нэмэлт санхүүжилтийн төвлөрүүлэх шилжүүлэг		3.00
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	<u>2,337,050,535.21</u>	<u>(819,882,434.35)</u>
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	370,485,513.25	146,156,222.08
Үндсэн хөрөнгө, бараа материал худалдсаны олз	370,485,513.25	146,156,222.08
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	-	133,838,169.46
Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	-	133,838,169.46
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	<u>370,485,513.25</u>	<u>12,318,052.62</u>
НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	2,707,536,048.46	(807,564,381.73)

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан /төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	825,785,858.49	1,158,450,832.10
ТАТВАРЫН БУС ОРЛОГО	221,964,258.49	309,229,532.10
Нийтлэг татварын бус орлого	221,964,258.49	309,229,532.10
Төсөв байгууллагын өөрийн орлого	221,964,258.49	309,229,532.10
Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	46,181,245.18	106,413,520.00
Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	175,783,013.31	202,816,012.10
ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	603,821,600.00	849,221,300.00
Улсын төвлөрсөн төсвөөс	587,143,100.00	817,708,200.00
Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	587,143,100.00	817,708,200.00
Нэмэлт санхүүжилтийн орлого	16,678,500.00	31,513,100.00
Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	16,678,500.00	11,213,100.00
Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	20,300,000.00
НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	806,095,764.64	1,157,350,925.95
УРСГАЛ ЗАРДАЛ	806,095,764.64	1,157,350,925.95
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	768,259,150.71	1,088,612,191.29
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	297,120,438.10	387,809,177.02
Үндсэн цалин	249,572,183.32	270,780,902.92
Нэмэгдэл	27,443,254.78	88,596,439.19
Унаа хоолны хөнгөлөлт	20,105,000.00	28,431,834.91
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	38,223,032.28	52,036,814.60
Тэтгэврийн даатгал	26,543,086.75	36,581,593.69
Тэтгэмжийн даатгал	2,871,908.02	3,919,392.51
ҮОМШӨ-ний даатгал	2,667,118.16	3,122,066.92
Ажилгүйдлийн даатгал	552,758.53	765,061.76
Эрүүл мэндийн даатгал	5,588,160.82	7,648,699.72
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	96,024,946.00	157,030,058.80
Гэрэл, цахилгаан	26,743,489.00	30,039,050.80
Түлш, халаалт	60,988,750.00	112,511,990.00
Цэвэр, бохир ус	5,892,707.00	3,919,018.00
Байрны түрээс	2,400,000.00	10,560,000.00
Хангамж, бараа материалын зардал	23,796,599.48	34,196,559.62
Бичиг хэрэг	2,969,100.00	2,981,700.00
Тээвэр, шатахуун	15,390,000.00	10,338,000.00
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	4,057,839.48	5,672,749.62
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,379,660.00	15,204,110.00
Нормативд зардал	3,998,500.00	600,000.00
Нормын хувцас, зөөлөн эдлэл	3,998,500.00	600,000.00

Малын удмын сангийн үндэсний төвийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Эд хогшил, урсгал засварын зардал	10,377,320.00	126,001,530.00
Багаж, техник, хэрэгсэл	1,185,030.00	108,159,400.00
Урсгал засвар	9,192,290.00	17,842,130.00
Томилолт, зочны зардал	5,564,504.15	6,162,380.00
Дотоод албан томилолт	5,564,504.15	6,162,380.00
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	245,687,746.05	317,682,471.25
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	245,005,022.05	316,867,341.25
Даатгалын үйлчилгээ	-	115,830.00
Тээврийн хэрэгслийн татвар	613,564.00	277,300.00
Тээврийн хэрэгслийн оношилгоо	-	22,000.00
Мэдээлэл, технологийн үйлчилгээ	-	400,000.00
Газрын төлбөр	69,160.00	-
Бараа үйлчилгээний бусад зардал	47,466,064.65	7,093,200.00
Бараа үйлчилгээний бусад зардал	47,466,064.65	7,093,200.00
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	37,836,613.93	68,738,734.66
Бусад урсгал шилжүүлэг	2,771,580.00	56,000,083.80
Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	-	54,300,083.80
Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,771,580.00	1,700,000.00
Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	12,738,650.86
Төвлөрүүлэх шилжүүлэг	-	12,738,647.86
Нэмэлт санхүүжилтийн төвлөрүүлэх шилжүүлэг		3.00
Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	35,065,033.93	-
Төвлөрүүлэх шилжүүлэг	35,065,033.93	
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>19,690,093.85</u>	<u>1,099,906.15</u>
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	19,690,000.00	1,100,000.00
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	19,690,000.00	1,100,000.00
Дотоод эх үүсвэрээр	19,690,000.00	1,100,000.00
Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	19,690,000.00	1,100,000.00
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	<u>(19,690,000.00)</u>	<u>(1,100,000.00)</u>
НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	93.85	(93.85)
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		93.85
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	93.85	

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан /төгрөгөөр/

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,604,070,935.15	608,934,364.40	17,619,466,006.47	19,832,471,306.02
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт			2,450,000,000.00	2,450,000,000.00
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,604,070,935.15	608,934,364.40	20,069,466,006.47	22,282,471,306.02
Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	2,707,536,048.46	2,707,536,048.46
2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,604,070,935.15	608,934,364.40	22,777,002,054.93	24,990,007,354.48
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,604,070,935.15	608,934,364.40	22,782,561,060.69	24,995,566,360.24
Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	-807,564,381.73	-807,564,381.73
2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	<u>1,604,070,935.15</u>	<u>608,934,364.40</u>	<u>21,974,996,678.96</u>	<u>24,188,001,978.51</u>

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан /төгрөгөөр/

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,173,139,900.00	1,114,199,178.09	58,940,721.91	95.0
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,173,139,900.00	1,114,199,178.09	58,940,721.91	95.0
УРСГАЛ ЗАРДАЛ	1,173,139,900.00	1,114,199,178.09	58,940,721.91	95.0
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,116,989,800.00	1,058,199,094.29	58,790,705.71	94.7
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	392,364,200.00	387,809,177.02	4,555,022.98	98.8
Үндсэн цалин	272,959,700.00	270,780,902.92	2,178,797.08	99.2
Нэмэгдэл	94,854,800.00	88,596,439.19	6,258,360.81	93.4
Унаа хоолны хөнгөлөлт	24,549,700.00	28,431,834.91	(3,882,134.91)	115.8
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	52,969,100.00	52,036,814.60	932,285.40	98.2
Тэтгэврийн даатгал	37,274,600.00	36,581,593.69	693,006.31	98.1
Тэтгэмжийн даатгал	3,923,600.00	3,919,392.51	4,207.49	99.9
ҮОМШӨ-ний даатгал	3,138,900.00	3,122,066.92	16,833.08	99.5
Ажилгүйдлийн даатгал	784,700.00	765,061.76	19,638.24	97.5
Эрүүл мэндийн даатгал	7,847,300.00	7,648,699.72	198,600.28	97.5
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	171,613,500.00	157,030,058.80	14,583,441.20	91.5
Гэрэл, цахилгаан	34,274,400.00	30,039,050.80	4,235,349.20	87.6
Түлш, халаалт	122,637,100.00	112,511,990.00	10,125,110.00	91.7
Цэвэр, бохир ус	4,642,000.00	3,919,018.00	722,982.00	84.4
Байрны түрээс	10,060,000.00	10,560,000.00	(500,000.00)	105.0
Хангамж, бараа материалын зардал	20,827,900.00	20,026,859.62	801,040.38	96.2
Бичиг хэрэг	3,053,500.00	2,481,700.00	571,800.00	81.3
Тээвэр, шатахуун	9,213,700.00	9,213,000.00	700.00	100.0
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	5,901,200.00	5,672,749.62	228,450.38	96.1
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,659,500.00	2,659,410.00	90.00	100.0
Эд хогшил, урсгал засварын зардал	126,382,100.00	126,001,530.00	380,570.00	99.7
Багаж, техник, хэрэгсэл	108,160,000.00	108,159,400.00	600.00	100.0
Урсгал засвар	18,222,100.00	17,842,130.00	379,970.00	97.9
Томилолт, зочны зардал	6,756,400.00	6,162,380.00	594,020.00	91.2
Дотоод албан томилолт	6,756,400.00	6,162,380.00	594,020.00	91.2
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	337,099,300.00	302,039,074.25	35,060,225.75	89.6
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	333,233,300.00	300,123,944.25	33,109,355.75	90.1
Даатгалын үйлчилгээ	185,500.00	115,830.00	69,670.00	62.4
Тээврийн хэрэгслийн татвар	366,500.00	277,300.00	89,200.00	75.7

Малын удмын сангийн үндэсний төвийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Тээврийн хэрэгслийн оношлогоо	198,000.00	22,000.00	176,000.00	11.1
Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,500,000.00	1,500,000.00	-	100.0
Газрын төлбөр	1,616,000.00	-	1,616,000.00	-
Бараа үйлчилгээний бусад зардал	8,977,300.00	7,093,200.00	1,884,100.00	79.0
Бараа үйлчилгээний бусад зардал	8,977,300.00	7,093,200.00	1,884,100.00	79.0
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	56,150,100.00	56,000,083.80	150,016.20	99.7
Бусад урсгал шилжүүлэг	56,150,100.00	56,000,083.80	150,016.20	99.7
Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	54,300,100.00	54,300,083.80	16.20	100.0
Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,850,000.00	1,700,000.00	150,000.00	91.9
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,173,139,900.00	1,114,199,178.09	58,940,721.91	95.0
ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	817,708,200.00	804,969,552.14	12,738,647.86	98.4
Орон нутгийн төсвөөс	817,708,200.00	804,969,552.14	12,738,647.86	98.4
ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	355,431,700.00	309,229,532.10	46,202,167.90	87.0
Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	133,900,000.00	106,413,520.00	27,486,480.00	79.5
Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	221,531,700.00	202,816,012.10	18,715,687.90	91.6
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		93.85	(93.85)	
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	93.85	-	93.85	-

2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

АУДИТ ХИЙСЭН НЭМЭЛТ САНХҮҮЖИЛТИЙН ТАЙЛАН

Тайлант хугацаа: 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан/

/ төгрөгөөр /

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН		31,513,100.00
УРСГАЛ ЗАРДАЛ		31,513,100.00
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		31,513,100.00
Хангамж, бараа материалын зардал		14,169,700.00
Бичиг хэрэг		500,000.00
Тээвэр, шатахуун		1,125,000.00
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс		12,544,700.00
Нормативт зардал		600,000.00
Нормын хувцас, зөөлөн эдлэл		600,000.00
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		16,743,400.00
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж		16,743,397.00
Олгосон санхүүжилт, шилжүүлэг		3.00
Улсын төсвөөс олгосон санхүүжилт, төвлөрүүлэх шилжүүлэг		3.00
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР		31,513,100.00
Нэмэлт санхүүжилтийн орлого		31,513,100.00
Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		11,213,100.00
Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого		20,300,000.00
НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)		
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		

3. Аудитын тайлан

3.1. Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасан бүрэн эрхийн хүрээнд Малын удмын сангийн үндэсний төвийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлтийг төсвийн захирагч П.Ганхуяг танд танилцуулж байна.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтад хийсэн үнэлгээ, аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал бүхий аудитын дүгнэлт түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан толилуулав.

Аудитын тайланд шалгагдагч этгээдэд худалдан авах ажиллагааны хууль, тогтоомжийг мөрдөж ажиллах, хөрөнгийг зориулалтын дагуу үр ашигтай зарцуулах талаар өгсөн зөвлөмжүүдийг менежментийн захидалд тусгасан болно.

Аудитыг 2021 оны 01 дүгээр сарын 25-наас 2021 оны 02 дугаар сарын 25-ны хооронд Үндэсний аудитын газрын захиалгаар “Дундманхайдай Аудит” ХХК-ийн захирал Ж.Бямбажав, аудитор Н.Тэмүүжин нар хариуцаж хэрэгжүүлэв.

Малын удмын сангийн үндэсний төвийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Үндэсний аудитын газар, “Дундманхайдай Аудит” ХХК-д 2020 оны 1 дүгээр сарын 22-ний өдрийн 15 дугаартай албан бичгээр ирүүлсэн байна.

3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй

Малын удмын сангийн үндэсний төвийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

Эрхэм зорилго:

Малын удмын сангийн үндэсний төв нь мал сүргийг генийн түвшинд төрийн хамгаалалтад авч, малын үржлийн ажил, үйлчилгээнд биотехнологи, генийн инженерчлэлийн дэвшилтэт аргыг нэвтрүүлснээр малын ашиг шим, бүтээмжийг нэмэгдүүлэн мах, сүүний дотоодын хэрэгцээг бүрэн хангаж, улмаар мал аж ахуйн бүтээгдэхүүний экспортыг нэмэгдүүлэх нөхцөлийг бүрдүүлнэ гэсэн эрхэм зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилтоо тодорхойлон ажиллажээ. Үүнд:

- Мал сүргийн удмын санг хамгаалах, ашиг шимийн гарц, чанарыг сайжруулах ажлыг зохион байгуулах, мал үржүүлэг, нөхөн үржихүйн чиглэлээр гаргасан эрдэм шинжилгээний ажлын үр дүнг үйлдвэрлэлд нэвтрүүлэх;
- Арвин ашиг шимт хээлтүүлэгч малын үр, хөврөл үрийг үйлдвэрлэх, үйлдвэр, үйлчилгээнд нэвтрүүлэх, нөөцлөх, генийн сан бий болгох;
- Цөм сүргийн үржлийн төв, мал бүхий иргэн, аж ахуйн нэгж, байгууллагыг үр, хөврөл үрээр хангах;
- Өндөр ашиг шимт хээлтүүлэгч малын үрээр зохиомол хээлтүүлэг хийх ажил, үйлчилгээ явуулах, тухайн үүлдрийн шилмэл ангийн жишигт нийцсэн хээлтэгч, хээлтүүлэгч бойжуулах;
- Улсын хэмжээнд үржүүлж байгаа арвин ашиг шимт цөм сүргийн малын удам гарвал, ашиг шимийн мэдээллийн сан бий болгож, дүн шинжилгээ хийх зэрэг болно.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Нийгмийн даатгалын шимтгэл хоёр хувиар нэмэгдсэн.
- Төрийн үйлчилгээний албан хаагчдад төрийн алба хаасан хугацааны нэмэгдлийг шинээр олгож эхэлсэн байна.

3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт

Малын удмын сангийн үндэсний төвийн 2020 оны санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн боловч зарим онцлог дансны харилцааг нэмж тусгуулах шаардлагатай байна.

ХХААХҮ-ийн яамны Хяналт, шинжилгээ, үнэлгээ дотоод аудитын газар 2020 онд тус захиргааны санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит хийгээгүй байна.

Малын удмын сангийн үндэсний төвийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд бага гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн үе шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

3.4. МАТЕРИАЛЛАГ БАЙДАЛ

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2020 оны үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшнийг “бага” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд сонгосон суурь үзүүлэлтийн дүн 999,984.4 мянган төгрөгөөс тооцон 19,999.6 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Гүйцэтгэлийн шатанд дахин хянаж материаллаг байдлын түвшнийг тооцоходоо суурийг 2020 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлаас 2 хувиар буюу 41,176.2 мянган төгрөгөөр тогтоолоо.

3.5. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Малын удмын сангийн үндэсний төвийн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 717,361.2 мянган төгрөгөөр буюу 2.9 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс авлага 152,711.3 мянган төгрөгөөр, бараа материал 245,968.2 мянган төгрөгөөр, үндсэн хөрөнгө 348,681.6 мянган төгрөгөөр тус тус буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Авлага	2,878,131.7	2,725,420.4	(152,711.3)
Урьдчилгаа			-
Бараа материал	4,554,949.8	4,308,981.6	(245,968.2)
Үндсэн хөрөнгө	17,600,027.4	17,251,345.8	(348,681.6)
Нийт хөрөнгө	25,003,109.0	24,285,747.8	(717,361.2)
Өр төлбөр	13,101.6	97,745.8	84,644.2
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	24,990,007.3	24,188,001.9	(802,005.4)
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	25,003,109.0	24,285,747.8	(717,361.2)

Мөнгөн хөрөнгө дансны оны эхний үлдэгдэл 93.85 мөнгийг бусдаар гүйцэтгүүлэх ажил үйлчилгээний зардалд зарцуулсан байна.

Авлага дансны үлдэгдлийг хувь хүнээс авах 152,711.3 мянган төгрөгөөр бууруулжээ. Авлага дансны эцсийн үлдэгдэлд 2009-2019 онуудад үүссэн, он удаан жил болсон Мал хамгаалах сан татан буугдаж балансаас балансад шилжин ирсэн 2,450,000.0 мянган төгрөг, хувь хүн, хуулийн этгээдээс авах 275,420.4 мянган төгрөгийн авлага байна.

Нийт авлагаас барагдуулах асуудал удааширсан, эрсдэлтэй 2,000,000.0 мянган төгрөгийн авлагыг шийдвэрлүүлэхээр шүүхэд өгсөн байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 245,968.2 мянган төгрөгөөр буурсан нь Төрийн өмчийн цөм сүргийн 11 аймгийн салбар нэгжийн мал маллаж байгаа малчидтай түрээсийн гэрээ байгуулан гэрээг дүгнэж ажлын хөлсийг малаар олгосон, хангамжийн материал, бэлэн бүтээгдэхүүнийг үйл ажиллагаанд зарцуулснаас шалтгаалжээ.

Тайлант оны эцэст 345,424.9 мянган төгрөгийн худалдан авалт хийж бараа материалын нөөц үүсгэсэн нь малын гений санг хамгаалах зохиомол хээлтүүлгийн гүн хөлдөөсөн үр хадгалах биобанк, биотанк, зохиомол хээлтүүлэг хийх зориулалтын багаж, Малын удмын сангийн үндэсний төвийн цогцолбор хотоос зайтай байрладаг тул халаалтад зориулж нүүрс худалдан авч нөөцөлснөөс шалтгаалсан байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 19,226,834.2 мянган төгрөг болж 282,000.2 мянган төгрөгөөр өссөн нь цөм сүргийн хадлан тэжээл бэлтгэх зорилгоор төсвийн хөрөнгөөр 90,290.3 мянган төгрөгийн машин тоног төхөөрөмж бэлтгэж, хандиваар 11,000.0 мянган төгрөгийн тээврийн хэрэгсэл, өмнөх оны бүртгэлд тусгагдаагүй 180,709.9 мянган төгрөгийн машин тоног төхөөрөмжийг данс бүртгэлд тусгаж нэмэгдүүлснээс тус тус шалтгаалжээ.

Биет бус хөрөнгө 1,100.0 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь үндсэн хөрөнгө, бараа материалын QR кодыг ашиглах хэрэгжүүлэх зорилгоор программ хангаж худалдан авсан байна.

Өр төлбөр дансны үлдэгдэл 84,644.2 мянган төгрөгөөр өссөн нь цөм сүргийн салбар нэгжийн хадлан тэжээлийг өөрийн хүчээр бэлтгэх зорилгоор 90,290.3 мянган төгрөгөөр тээврийн хэрэгсэл худалдан авснаас шалтгаалжээ.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 802,005.2 мянган төгрөгөөр буурсан нь цөм сүргийн 11 аймгийн салбар нэгжийн мал маллаж байгаа малчидтай түрээсийн гэрээ байгуулан гэрээг дүгнэж ажлын хөлсийг олгосноос шалтгаалжээ. Энэ нь үйл ажиллагааны нийт үр дүнд 807,564.3 мянган төгрөгөөр алдагдалтай ажиллахад нөлөө үзүүлсэн байна.

Нийт зардал өмнөх оноос 148,175.1 мянган төгрөгөөр буурсан нь COVID-19 цар тахал дотооддоо дэгдэж, бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжин, үйл ажиллагаа түр хязгаарлагдсанаас шалтгаалсан байна.

3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2020 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 3,975,172.7 мянган төгрөгөөр, нийт зардлыг 3,975,172.7 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс ажилчдын 24 айлын орон сууц, 16 хүний суудалтай автобус, шингэн азот түгээх зориулалтаар тоноглогдсон авто машин нийт 2,802,032.0 мянган төгрөгийн төсвийг хасаж баталжээ.

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 10 хөтөлбөрийн 21 арга хэмжээнд санхүүжүүлэхээр 1,173,139.7 мянган төгрөгийн төсөв баталснаас 817,708.2 мянган төгрөгийг улсын төсвөөс, 355,431.5 мянган төгрөгийг үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжүүлэхээр төлөвлөжээ

Төсвийн гүйцэтгэл

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 817,708.2 мянган төгрөгийн санхүүжилт авч, үндсэн болон туслах үйл ажиллагааны орлогоос 309,229.5 мянга, нийт 1,126,937.7 төгрөгийн орлого бүрдүүлж 1,114,199.2 мянган төгрөгийг зарцуулж 12,738.5 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн зардал 1,114,199.0 мянган төгрөг буюу 95.6 хувийн гүйцэтгэлтэй байна.

Нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Дээд шатны төсвийн захирагчаас 11,213.1 мянга, үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 20,300.00 мянга нийт 31,513.1 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлсэн. Үүнээс хангамж бараа материалд 14,169.7 мянга, нормативд 600.0 мянга, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамжид 16,743,3 мянга, нийт 31,513.0 мянган төгрөгийг зарцуулжээ.

3.7. Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 144 мэдээллээс 19 мэдээллийг хугацаа хоцроосон ба таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авалт 230,181.4 мянган төгрөгийн 9 гүйлгээ, цалингийн зардлаас бусад зардал болох 175,179.7 мянган төгрөгийн 14 гүйлгээний мэдээлэл, орлогын 133,883.5 мянган төгрөгийн 16 гүйлгээний мэдээллийг тус тус цахим хуудсанд байршуулсан байна.

3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 189,471.0 мянган төгрөгийн актыг тогтоож, зөрчлийг арилгах 2 албан шаардлага өгөгдсөнөөс актын биелэлт 96.4 хувьтай, албан шаардлагын биелэлт 50.0 хувьтай байна.

Хүснэгт 3 Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн төлбөрийн акт, албан шаардлагын хэрэгжилт.

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	1	189,471.0	1	182,771.0	1	6,700.0	3.5
Албан шаардлага	2	162,333.1	1	158,333.1	1	4,000.0	50.0
Нийт дүн	3	351,804.1	2	345,104.1	1	6,700.0	

3.9. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 649,143.8 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 608,810.1 мянган төгрөгийн алдааг залруулж, 10,873.7 мянган төгрөгийн зөрчилд 2 төлбөрийн акт тогтоож, 6,700.0 мянган төгрөгийн зөрчлийг арилгах албан шаардлага, 22,760.0 мянган төгрөгийн алдаа давтан гаргахгүй байх 2 зөвлөмж өглөө.

Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн дансны бичилт болон тайлагналтай холбоотой дараах алдааг санхүүгийн тайланд залруулсан. Үүнд:

1. Тайлант үеийн санхүү байдлын тайлангийн эхний үлдэгдэл өмнөх оны аудитлагдсан тайлангийн эцсийн үлдэгдлээс 528,045.1 мянган төгрөг зөрүүтэй тайлагнасан;
2. Мөнгөн хөрөнгөөс шуудан холбоо, цахилгаан, халаалт, цэвэр ус, бараа материал, сургалт, томилолт, заавар материал зэрэг нийт 65,433.5 мянган төгрөгийн ажил гүйлгээг шууд зардлаар бүртгэсэн;
3. Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардлыг 2,530.3 мянган төгрөгийн гүйлгээний дансны бичилтийг буруу бүртгэсэн;
4. Урсгал засварын зардал 12,801.2 мянган төгрөгийн гүйлгээг хоорондын тооцооны дансаар дамжуулаагүй шууд зардлаар бүртгэсэн байна.

Шийдвэрлэсэн нь: Санхүүгийн тайланд залруулга хийлгэсэн.

Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил

Аудитаар 40,333.7 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа, зөрчил илэрснээс 10,873.7 мянган төгрөгийн төлбөрийн акт тогтоож, 6,700.0 мянган төгрөгт албан шаардлага өгөв. Үүнд:

1. Албан тушаалын болон албан ажлын зорилгоор суудлын автомашин хэрэглэх эрх бүхий албан тушаалтанд унааны мөнгө 995.5 мянган төгрөгийг давхардуулан олгосон нь: Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулах", 6.4.8 дахь "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх" гэсэн заалтуудыг зөрчсөн ба "Оршин байх", "Үнэн зөв байх", "Иж бүрэн байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоохоор шийдвэрлэв.

2. Завхан аймгийн Цөм сүргийн нэгжийн захиралд Шүүхийн шийдвэрийн дагуу ажлаас халагдсаны нэг удаагийн тэтгэмж 9,878.2 мянган төгрөгийг өөрийн орлогоос олгосон нь: Захиргааны ерөнхий хуулийн 103-р зүйлийн 103.1-д Иргэн хуулийн этгээдийн хохирлыг барагдуулсаны улмаас өөрт учирсан хохирлыг захиргааны байгууллага Иргэний хуулийн 498.5 д заасан гэм буруутай албан тушаалтнаар буцааж төлүүлнэ, Төрийн албаны тухай хуулийн 50 дугаар зүйлийн 50.1-т "Төрийн жинхэнэ албан хаагчийг хууль бусаар төрийн албанаас чөлөөлсөн, түр чөлөөлсөн, халсныг төрийн албаны төв байгууллага, эсхүл шүүх тогтоосон бол төрд учруулсан хохирлыг уг шийдвэрийг гаргасан буруутай албан тушаалтнаар нөхөн төлүүлнэ" гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоохоор шийдвэрлэв.

3. Өмнөх аудитын тайлангаар тавигдсан актын дутуу 6,700.0 мянган төгрөгийн үлдэгдлийг барагдуулаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг арилгах албан шаардлага өгөхөөр шийдвэрлэв.

Аудитын зөвлөмж

Аудитаар илэрсэн 22,760.0 мянган төгрөгийн алдаа, зөрчилд 2 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгав.

3.10. Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд

Үндсэн хөрөнгийн дансанд ашиглаж байгаа боловч үлдэх өртөг "0" үлдэгдэлтэй болсон 819,625.3 мянган төгрөгийн анхны өртөгтэй 349 нэр төрлийн хөрөнгүүдийг үнэлэх асуудлыг шийдвэрлэсэн байдал болон цөм сүргийн төслийн нэгжийн шатахуун зарцуулалтад дараагийн аудитаар нарийвчилсан горим сорил хэрэгжүүлнэ.

4. Менежментийн захидал

Менежментийн захидалд цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

1. Худалдан авалт болон гэрээний биелэлт, хэрэгжилттэй холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт:

Бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ерөнхий төлөвлөгөө болон тодотгосон төлөвлөгөөнд тусгагдаагүй ажил үйлчилгээг /Өвс 22,350.0 мянган төгрөг/ шууд худалдан авах гэрээ байгуулан гүйцэтгэсэн.

1.2. Эрсдэл:

Холбогдох хууль, журам зааврыг зөрчигдөх, зориулалт бус, үр ашиггүй зардал гарах, тайлан буруу илэрхийлэгдэх.

1.3. Өгсөн зөвлөмж:

Бараа, ажил, үйлчилгээ худалдан авахдаа Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль болон холбогдох журам заавар, байгууллагын жилийн худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг мөрдөж ажиллах.

1.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Бараа үйлчилгээ худалдан авах малын тэжээл, өвс гэрээ байгуулан авсан. Зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллах болно.

2. Зардлын данстай холбоотой асуудал

2.1. Илрүүлэлт:

Тус байгууллагын хөрөнгөд бүртгэлгүй, ажилтны хувийн автомашинд тушаал, шийдвэргүйгээр шатахуун олгож зарцуулсан, шатахууны зарлагын баримтад хүлээн авсан, олгосон хүний гарын үсэг зурж баталгаажуулаагүй байна.

2.2. Эрсдэл:

Санхүүгийн тайлан буруу илэрхийлэгдэх, төсвийг зориулалт бус, үрэлгэн зарцуулсан байх.

2.3. Өгсөн зөвлөмж:

Төсвийг үр ашигтай хэмнэлттэй байхаар төлөвлөж, зориулалтын дагуу зарцуулах, анхан шатны баримтын бүрдлийг хангаж, Нягтлан бодох бүртгэл, Төсвийн тухай хуулийг мөрдөж ажиллах.

2.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Хөдөө орон нутагт тээврийн хэрэгсэл дутагдалтай байдгаас шатахууны талон олгон ажил үүрэг гүйцэтгэж байна. Зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2021 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо: 2021.02.25	Аудитын нэр: Малын удмын сангийн үндэсний төвийн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит	Аудитын код: САГ-2021/12/СТА-ТШЗ
Шалгагдсан байгууллагын нэр:	Малын удмын сангийн үндэсний төв	Мянган төгрөг

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Албан тушаал	Овог нэр
1	2	3	4	5	6
1	Албан тушаалын автомашин хэрэглэсэн албан тушаалтанд давхардуулан 995.5 мянган төгрөгийн унааны мөнгөн олгосон	995.5	Акт тогтоов	Захирал Санхүү аж ахуйн дарга, Ерөнхий нягтлан бодогч	П.Ганхуяг Б.Отгонжаргал.
2	Шүүхийн шийдвэрээр Завхан аймгийн Цөм сүргийн нэгжийн захиралд 9.878.2 мянган төгрөгийг өөрийн орлогоос нэг удаагийн тэтгэмжийг олгосон	9,878.2	Акт тогтоов	Захирал Санхүү аж ахуйн дарга, Ерөнхий нягтлан бодогч	П.Ганхуяг Б.Отгонжаргал.
3	Өмнөх аудитын тайлангаар тавигдсан актын дутуу 6,700.0 мянган төгрөгийн үлдэгдлийг барагдуулаагүй	6,700.0	Албан шаардлага	Захирал Санхүү аж ахуйн дарга, Ерөнхий нягтлан бодогч	П.Ганхуяг Б.Отгонжаргал.
4	Бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ерөнхий төлөвлөгөө болон тодотгосон төлөвлөгөөнд тусгагдаагүй ажил үйлчилгээг /Өвс 22,350.0 мянган төгрөг/ шууд худалдан авах гэрээ байгуулан гүйцэтгэсэн.	22,350.0	Зөвлөмж	Захирал Санхүү аж ахуйн дарга, Ерөнхий нягтлан бодогч	П.Ганхуяг Б.Отгонжаргал.
5	Тайлант хугацааны шатахуун зарцуулалтын тайланг шалгахад тус байгууллагын хөрөнгөд бүртгэлгүй, ажилтны хувийн автомашинд тушаал, шийдвэргүйгээр шатахуун олгож зарцуулсан, шатахууны зарлагын баримтад хүлээн авсан, олгосон хүний гарын үсэг зурж баталгаажуулаагүй байна.	410.0	Зөвлөмж	Захирал Санхүү аж ахуйн дарга, Ерөнхий нягтлан бодогч	П.Ганхуяг Б.Отгонжаргал.



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АКТ

2021 оны 02 дугаар сарын 25

№ 07/АУ150053

Улаанбаатар хот

САГ-2021/12/ІСТА-ТУ13

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Малын удмын сангийн үндэсний төвийн 2020 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Дархан-уул аймгийн иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн 107 тоот магадлалаар Л.Лхаасүрэнд 9,878,247.00 /Есөн сая найман зуун далан найман мянган хоёр зуун дөчин долоон/ төгрөгийн тэтгэмжийг байгууллагаас олгосон байна.

Энэ нь Захиргааны ерөнхий хуулийн 103-р зүйлийн 103.1-д "Иргэн хуулийн этгээдийн хохирлыг барагдуулсаны улмаас өөрт учирсан хохирлыг захиргааны байгууллага Иргэний хуулийн 498.5 д заасан гэм буруутай албан тушаалтнаар буцааж төлүүлнэ", "Төрийн албаны тухай хуулийн 50 дугаар зүйлийн 50.1-т тус тус заасныг зөрчсөн байна.


Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно.", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журамдын 4.2.3-д заасныг үндэслэн **ТОГТООХ нь:**

1.Малын удмын сангийн үндэсний төв нь Шүүхийн шийдвэрээр Завхан аймгийн цөм сүргийн нэгжийн захиралд орлогоос нэг удаагийн тэтгэмжийг олгосон 9,878,247.00 төгрөгийг үндэсний аудитын газрын Төрийн сан банкин дахь Аудитын шалгалтын орлогын 100900000601 тоот дансанд төвлөрүүлэх.

2.Актын биелэлтийг 2021 оны 6 дугаар сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Малын удмын сангийн үндэсний төвийн захирал П.Ганхуяг, Нягтлан бодогч Б. Отгонжаргал нарт хариуцуулав.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН ЗАХИРАЛ,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
"ДУНДМАНХАЙДАЙ АУДИТ"
ХХК АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ
Д.ЭНХДАЛАЙ

Ж.БЯМБАЖАВ

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр,
Утас 51-264230

\\10.10.10.20\Bichig_Khereg\Akt\2021\0225auditin 2-R Газар7.Docx

001090400



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АКТ

2021 оны 02 дугаар сарын 25

№ 08/АДИС0053

Улаанбаатар хот

САГ-2021/12/СТА-ТЦУЗ

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Малын удмын сангийн үндэсний төвийн 2020 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

1. Албан тушаалын автомашин хэрэглэх эрх бүхий албан тушаалтанд унааны мөнгө 995.5 мянган төгрөгийг давхардуулан олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулах", 6.4.8 дахь "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил гүйлгээг гаргахаас өмнө хянан, баталгаажуулах", 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооцоо хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах", Санхүүгийн тайлангийн "Оршин байх", "Үнэн зөв байх", "Иж бүрэн байх" гэсэн батламж мэдэгдлүүдтэй тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно.", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.3-д заасныг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Албан тушаалын автомашин хэрэглэх эрх бүхий албан тушаалтанд давхардуулан олгосон унааны мөнгө 995,500.00 төгрөгийг буруутай албан тушаалтнаар төлүүлж үндэсний аудитын газрын Төрийн сан банкин дахь Аудитын шалгалтын орлогын 100900000601 тоот дансанд төвлөрүүлэх,
2. Актын биелэлтийг 2021 оны 6 дугаар сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Малын удмын сангийн үндэсний төвийн захирал П.Ганхуяг, Нягтлан бодогч Б. Отгонжаргал нарт хариуцуулав.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН ЗАХИРАЛ,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
"ДУНДМАНХАЙДАЙ АУДИТ"
ХХК АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ
Д.ЭНХДАЛАЙ

Ж.БЯМБАЖАВ

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр,
Утас 51-264210

\\10.10.10.20\Bichig_Khereg\Akt\2021\0225auditin 2-R Газар6.Docx

001090397



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2021 оны 02 дугаар сарын 25

№ 25/А0150053

Улаанбаатар хот

САГ-2021/12/СТА-ТШЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Малын удмын сангийн үндэсний төвийн 2020 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант хугацаанд өмнөх оны аудитын шалгалтаар тавигдсан 6,700,000.00 төгрөгийг төлж барагдуулаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ", 20 дугаар зүйлийн 20.2.6-д "... бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах", Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйл 6.4.8-д "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", Санхүүгийн тайлангийн "Оршин байх", "Үнэн зөв байх", "Иж бүрэн байх" батламж мэдэгдсэнтэй тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1-д заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Өмнөх оны аудитаар тавигдсан 6,700,000.00 төгрөгийн актыг зөрчлийг арилгаж, биелэлтийг 2021 оны 5 дугаар сарын 31-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх,
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Малын удмын сангийн үндэсний төвийн захирал П.Ганхуяг, Нягтлан бодогч Б. Отгонжаргал нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:
АУДИТЫН ХОЁР ДУГААР ГАЗРЫН ЗАХИРАЛ,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АУДИТЫН МЕНЕЖЕР

"ДУНДМАНХАЙДАЙ АУДИТ"
ХХК АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ

Д.ЭНХДАЛАЙ

Ж.БЯМБАЖАВ

